

**УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан .....	4
2.1	Оршил .....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10	Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын төлөвлөгөөний төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар:	9
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал .....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан .....	14
4.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан .....	15
4.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	17
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	18

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ХХОАТ	Хувь хvний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ  
УТҮГ-ЫН ЗАХИРАЛ С.ЭНХБАЯР  
ТАНАА

2019.03.14 № 06/429  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Засгийн газрын Авто бааз УТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг мөн.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус газрын захирал С.Энхбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг СТОУС, НББОУС, болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2019 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Эс Жи Эм Ди Аудит ХХК-ийн аудитын баг аудитыг хариуцаж хэрэгжүүлэв.

Засгийн газрын Авто бааз УТҮГ-аас 2018 оны санхүүгийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 1/23 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Засгийн газрын Авто бааз УТҮГ нь “Төр, засгийн төв байгууллагууд болон бусад хэрэглэгчдэд тээврийн үйлчилгээгээр тасралтгүй, түргэн шуурхай, соёлтой, найдвартай үйлчлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын шийдвэрээр Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр засгийн байгууллагуудад тээврээр үйлчлэх

Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын захирал нь дараах хууль болон СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Жолоочийн даатгалын тухай хууль
- Авто тээврийн тухай хууль
- Авто замын тухай хууль
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзээд шинээр батлагдсан бодлого, журамд “нийцсэн байна” гэж дүгнэсэн.

Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Засгийн газрын Авто бааз УТҮГ нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Ноён ” програм хангамж ашигладаг байна.

Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо, олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 13 эрсдэлтэй асуудлыг тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорилыг хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг цэвэр хөрөнгийн суурь үзүүлэлтээс 2.0 хувиар авахад тохиромжтой гэж үзэв.

Цэвэр хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон бөгөөд материаллаг байдлын суурийг нийт хөрөнгийн дүнгээс тооцоход их байгаа тул цэвэр хөрөнгийг суурь үзүүлэлт болгон сонгосон болно.

Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын 2018 оны цэвэр хөрөнгө 14,905.9 сая төгрөг бөгөөд түүний 2.0 хувь болох 298.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 9 чиглэлээр 36 горим сорил гүйцэтгэж үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 27 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 5 асуудлаар аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.



Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал  
(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	7.0	
2	Албан шаардлага өгсөн	2	70.8	
	<b>Дүн</b>	<b>4</b>	<b>77.8</b>	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### 2.8.1.1 Дотоод аудитын талаар:

2018 оны тайлант жилийн хугацаанд касст дунджаар 5.6 сая төгрөг байхад нэмж 5.2 сая төгрөг авч их хэмжээний бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байсан байна.

Энэ нь эрх үүргийн талаарх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, “Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6 дахь хэсэг “Төрийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа /бусад орлого/-наас орох орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэснийг мөрдөж ажиллаагүйн улмаас тайлант хугацааны эцэст 10.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

**Шийдвэрлэсэн:** Албан шаардлага өгөх

#### 2.8.1.2 Балансын данстай холбоотой асуудлаар:

Бараа материалын дансанд 60.8 сая төгрөгийн ашиглалтад байгаа хангамжийн зүйлс буюу бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс бүртгэгдсэн байна.

Энэ нь иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан

*шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*”, НББОУС 2-ын 6 (в) “*үйлдвэрлэлийн дамжлага эсвэл үйлчилгээ үзүүлэхэд ашиглах гэж байгаа материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа хөрөнгө*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Албан шаардлага өгөх

## **2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

- Шатахуун болон сэлбэг хэрэгслийн зарцуулалтын тайлан,
- Өглөг, авлагын тооцоо баталгаажуулалт,
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоолол,
- Түрээсийн орлогын бүртгэл,
- Улсын төсвөөс санхүүжиж байгаа цалингийн зардлын хэтрэлт,
- Худалдан авалтын талаар зэргийг нарийвчлан шалгах

## **2.10 Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын төлөвлөгөөний төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар:**

Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 6,361.2 сая төгрөгийн орлоготой, 6,337.9 сая төгрөгийн зардалтай, 9.8 сая төгрөгийн ашигтай ажиллах, нийт төлбөрт гүйлт 2.305.0 мянган км-ын төлөвлөгөөг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга баталсан байна.

“Засгийн газрын Авто бааз” УТҮГ нь 2018 онд нийт 5,768.3 сая төгрөгийн орлого олж, 5,656.0 сая төгрөгийн зардал гаргаж 112.3 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. Орлогын төлөвлөгөөг 90.7 хувиар биелүүлж, зардлын төлөвлөгөө 89.2 хувийн гүйцэтгэлтэй гарч төлөвлөгөөт ашгийг 82.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж ажилласан байна. Мөн нийт төлбөрт гүйлт гүйцэтгэлээр 2,580.8 мянган км, төлөвлөгөөг 111.9 хувиар биелүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төлөвлөгөөний төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, удирдлага нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага нь санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын Авто бааз УТҮГ нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Засгийн газрын Авто бааз УТҮГ нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 6,361.2 сая төгрөгийн төсөв батлагджээ.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Засгийн газрын Авто бааз УТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны мэдээллээр цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш, орлого зарлагын 202 удаагийн 3,138.9 сая төгрөгийн гүйлгээг мэдээлсэн байна. Мөн тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн тайлан /жилийн эцсийн болон хагас жилийн/, 2017 төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, тендер, худалдан авалт болон байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт зэргийг мэдээлсэн байна.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Засгийн газрын Авто бааз УТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Засгийн газрын Авто бааз УТҮГ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Дотоод аудитын талаар:**

##### *1.1 Илрүүлэлт:*

2018 онд “Монгол хьондай автомотив” ХХК-иас бусад түрээслэгчийн түрээсийн гэрээг шинэчлээгүй, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар батлуулаагүй, гэрээнд түрээслэгчийн гэрээний үүргийн биелэлтийн баталгаа болох барьцаа хөрөнгийн талаар тусгаагүй байна.

Энэ нь иж бүрэн байдлын талаарх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 293 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3.3 “Иргэн, хуулийн этгээд нь түрээслэгчийн гэрээний үүргийн биелэлтийн баталгаа болгож 1 (нэг) сарын төлбөртэй тэнцэх хэмжээний буюу (.....) төгрөгийг барьцаа болгон арилжааны банканд энэхүү гэрээний хугацаанд байршуулна.” заалтуудыг тус тус зөрчсөн байна.

##### *1.2 Эрсдэл:*

- Холбогдох хууль журмыг хэрэгжүүлж ажиллагаагүй,
- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэнэ,

### 1.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар төвлөрүүлэх орлогыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 120 дугаар тогтоолын дагуу аккруэл сууриар бүртгэж байх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 293 дугаар тогтоолын 3.3 дугаар заалтыг мөрдөж ажиллах,

### 1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид залруулж анхааран ажиллана.

## 2. Балансын данстай холбоотой асуудлын талаар:

### 2.1 Илрүүлэлт:

Жилийн эцсийн байдлаар 11 байгууллага, хувь хүнтэй холбоотой тээврийн үйлчилгээ үзүүлснээс үүссэн 40.7 сая төгрөгийн авлагатай байна. Үүнээс Ерөнхийлөгчийн Тамгын газар, Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон хувь хүнтэй үүссэн нийт 7.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.”дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэсэн заалтыг зөрчсөн байна.

### 2.2 Эрсдэл:

- Авлагын дүн буруу илэрхийлэгдэнэ,
- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,

### 2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах

### 2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тайлант хугацаанд өр авлагыг барагдуулан ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, тээврийн үйлчилгээний авлагыг 40 хувь хүртэл бууруулан ажиллалаа. Гэрээнд тусгагдсаны дагуу нэр бүхий 3 байгууллага, хувь хүнээс тээврийн төлбөрийг нэхэмжлэн, бүртгэл тооцоонд тусгасан ба 2019 оны 1 дүгээр улиралд тээврийн үлдэгдэл тооцоог барагдуулахаар ажиллаж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018.01.01	2018.12.31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	707,962,489.00	885,466,410.52
1.1.2	Дансны авлага	41,382,168.70	60,406,615.60
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	1,091,647.05	1,843,502.15
1.1.4	Бусад авлага	328,617,711.80	225,696,615.14
1.1.6	Бараа материал	82,793,378.06	83,853,350.34
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,161,847,394.61</b>	<b>1,257,266,493.75</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	10,863,516,662.22	12,982,882,803.89
1.2.2	Биет бус хөрөнгө	579,166.62	718,836,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	43,414,999.41
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>10,864,095,828.84</b>	<b>13,745,133,803.30</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,025,943,223.45</b>	<b>15,002,400,297.05</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	27,442,770.00	0.00
2.1.1.3	Татварын өр	25,119,790.92	25,455,588.48
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,854,400.00	24,919,254.00
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>54,416,960.92</b>	<b>50,374,842.48</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>54,416,960.92</b>	<b>50,374,842.48</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	11,744,520,814.45	11,744,520,814.45
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	2,132,191,677.04
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	718,836,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	227,005,448.08	356,476,963.08
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>11,971,526,262.53</b>	<b>14,952,025,454.57</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>12,025,943,223.45</b>	<b>15,002,400,297.05</b>

## 4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>1,492,075,998.22</b>	<b>1,681,505,937.22</b>
2	Борлуулалтын өртөг	1,919,288,979.65	2,290,317,774.84
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>(427,212,981.43)</b>	<b>(608,811,837.62)</b>
6	Ногдол ашгийн орлого (Татаас, санхүүжилтийн орлого)	2,391,689,700.00	2,412,668,900.00
8	Бусад орлого	1,165,813,846.40	1,724,931,342.27
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,839,146,452.24	3,092,510,468.87
10	Ерөнхий ба удирдлагын зардал	87,582,366.00	96,557,600.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(95,169.93)	327,387.11
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(69,277,572.00)	0.00
<b>17</b>	<b>Бусад ашиг ( алдагдал)</b>	<b>(119,661,639.00)</b>	<b>(176,571,435.60)</b>
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>14,527,365.80</b>	<b>163,476,287.29</b>
<b>19</b>	<b>Орлогын татварын зардал</b>	<b>13,418,900.48</b>	<b>34,004,772.28</b>
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>1,108,465.32</b>	<b>129,471,515.00</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>1,108,465.32</b>	<b>129,471,515.00</b>
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>1,108,465.32</b>	<b>129,471,515.00</b>



### 4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Энгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Ийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2017 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл</b>	<b>11,744,520,814.45</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>225,896,982.76</b>	<b>11,970,417,797.21</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					0.00
3	Залруулсан үлдэгдэл					0.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	0.00	0.00	0.00	1,108,465.32	1,108,465.32
5	Бусад дэлгэрэнгүй орлого					0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт					0.00
7	Зарласан ногдол ашиг					0.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					0.00
9	<b>2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>11,744,520,814.45</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>227,005,448.08</b>	<b>11,971,526,262.53</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					0.00
11	Залруулсан үлдэгдэл					0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				129,471,515.00	129,471,515.00
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	2,132,191,677.04	718,836,000.00	0.00	2,851,027,677.04
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	<b>2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b>	<b>11,744,520,814.45</b>	<b>2,132,191,677.04</b>	<b>718,836,000.00</b>	<b>356,476,963.08</b>	<b>14,952,025,454.57</b>

#### 4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>4,071,508,666.47</b>	<b>4,622,352,422.48</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,219,521,809.76	1,640,404,119.15
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	4,920,733.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	2,391,689,700.00	2,412,668,900.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	460,297,156.71	564,358,670.33
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>3,574,688,413.38</b>	<b>4,283,303,920.96</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,629,605,091.00	1,716,308,428.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	443,564,892.00	522,999,287.30
1.2.3	Түүхий эд материал худалдан авахад төлсөн	12,399,298.00	2,372,930.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	186,673,644.37	336,106,528.10
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	774,610,020.00	993,563,235.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	187,531,488.24	214,998,119.84
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	54,000.00	1,388,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	340,249,979.77	495,567,392.72
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>496,820,253.09</b>	<b>339,048,501.52</b>
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>187,310,930.00</b>	<b>161,544,580.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	187,310,930.00	161,544,580.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(187,310,930.00)</b>	<b>(161,544,580.00)</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>309,509,323.09</b>	<b>177,503,921.52</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>398,453,165.91</b>	<b>707,962,489.00</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>707,962,489.00</b>	<b>885,466,410.52</b>

## 5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Аудитын нэр:</b>	Засгийн газрын Авто баазын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит		
<b>Огноо:</b>	2019.03.15	<b>Аудитын код:</b>	САГ-2019/110/СТА-ТӨҮГ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	Засгийн газрын Авто бааз	<b>Сая төгрөгөөр:</b>	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая төгрөг/	Гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
А	3	4	8	9	10
1	2018 онд Монгол хьондай автомотив ХХК-с бусад түрээсийн гэрээг шинэчлээгүй. -Түрээсийн гэрээг ТӨБЗ-ын газраар батлуулаагүй. /Гурвалсан гэрээгүй/ - Монгол хьондай автомотив ХХК-с бусад гэрээнд түрээслэгчийн гэрээний үүргийн биелэлтийн баталгаа болох барьцаа хөрөнгийн талаар тусгаагүй байна.		Зөвлөмж өгөх	Захирал	С.Энхбаяр
2	Жилийн эцсийн байдлаар 11 байгууллага, хувь хүнтэй холбоотой Тээврийн үйлчилгээ үзүүлсэнээс үүссэн 40,735.9 мянган төгрөгийг авлагатай байна. Үүнээс ЕТГазар 2,742.9 мянган төгрөг /зөвлөхүүдийн лимит хэтрэлт/, хувь хүнтэй үүссэн 770.0 мянган төгрөг, ТЗҮЭГазар 1,475.7 мянган төгрөг /Лосол, Болдбаатар/, БОНХЯам /төслийн ажилтанууд/-тай 2.024.6 мянган төгрөгийн бүгд 7,013.2 мянган төгрөгийн авлагын тооцоо нийлээгүй байна.	7.0	Зөвлөмж өгөх	Захирал	С.Энхбаяр
3	Бараа материалын дансанд 60,824.9 мянган төгрөгийн Ашиглалтанд байгаа бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс бүртгэгдсэн байна.	60.8	Албан шаардлага өгөх	Захирал	С.Энхбаяр
4	Бэлэн мөнгөөр 55,429.1 мянган төгрөг /Түрээс болон гаражийн төлбөр, тээврийн хөлс, шатахууны төлөлт, цалингийн урьдчилгааны буцаан төлөлт/-ийн орлого орсон. -Кассанд бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байхад их хэмжээний мөнгө харилцахаас авсан байна: Үүнээс: 2 сарын 13-нд 4,070.0 төгрөгийн үлдэгдэлтэй байхад харилца-хаас 10 сая төгрөг авсан. 4/3-нд 5,139.7 м/т+4 сая төгрөг, 7/26-нд 5,019.3 м/т+4,5 сая төгрөг, 7/27-нд 7,910.5 м/т+2,5 сая төгрөг, 9/28-нд 4,448.7 м/т+4,5 сая төгрөг, 11/12-нд 1,267.9 м/т +9 сая төгрөг, 11/27-нд 7,524.0 м/т+4,5 сая төгрөг, 12/7-нд 4,306.1 м/т байхал 4,5 сая төгрөг, 12/12-нд 7,437.3 м/т+4,5 сая төгрөг, 12/13-нд 9,837.3 м/т +4,5 сая төгрөг	10.0	Албан шаардлага өгөх	Захирал	С.Энхбаяр
	<b>Дүн</b>	<b>77.8</b>			

